



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

10/8 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
грант олгох журам батлах тухай

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 3 дугаар заалтын 3.7.3, 3.7.4-т  
заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
грант олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Грантаар олгох санхүүжилтийг жил бүр захирлын тушаалаар тусгайлан  
тогтоож байх нь зүйтэй гэж үзсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрдэмтэн нарийн бичгийн  
даргад даалгасугай.

ЗАХИРАЛ

С.ЭНХЦЭЦЭГ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын  
2018 оны 4 дугаар сарын 22-ны өдрийн  
4/01. тоот тушаалын хавсралт

## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ГРАНТ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор грант олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Грант нь "Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх эсэг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 2 дугаар заалтын 2.1.1-2.1.4-т заасны ягуу онолын суурь болон хавсарга судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэх хэлбэр байна.

Тайлбар: "Грант гэдэгт иргэн, хуулийн этгээд тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулахаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцоход нь буцалтгүй, эргэн төлүүлэхгүйгээр олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгө"-ийг ойлгоно.

1.3. Нийгмийн бодит хэрэгцээ болгох боломжтой онолын суурь болон практик удалгааны ажилд завсрын болон эцсийн үр дүнд зайлшгүй шаардлагатай нэмэлт судалгаа, ооцоо, үндэслэл, боловсруулалт хийлгэх зорилгоор иргэн хуулийн этгээдэд грантыг нэг жил үртэл хугацаатай олгоно.

Тайлбар: Хууль зүйн шинжлэх ухааны салбарт төрийн бодлого боловсруулахад шинжлэх ухааны үндэслэл болохуйц судалгааны үр дүн, олон нийтийн оюуны хэрэгцээг ангахуйц ном бүтээлийг бодит хэрэглээнд тооцно.

1.4. Грантаар санхүүжүүлэх ажлын хамтран гүйцэтгэгч нь магистрант болон оюутан іайж болно.

1.5. Грантын зохих хувийг судалгааны ажилд зайлшгүй шаардлагатай ном, сэтгүүл, оног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон бусад материал худалдан авахад зарцуулж болох өгөөд гадаад томилолтын болон суралцах зардалд зориулахыг хориглоно.

1.6. Грантын 40 хүртэлх хувийг гүйцэтгэгчийн цалинд зарцуулж болно.

### Хоёр. Грантаар санхүүжүүлэх судалгааны үр дүнг сонгох, баталгаажуулах

2.1. Судалгааны ажлыг грантаар санхүүжүүлэх саналыг иргэн, хуулийн этгээд нээлттэй эгах эрхтэй.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан саналыг холбогдох бичиг баримтын хамт Хууль зүйн дэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл /цаашид "Эрдмийн зөвлөл" гэх/-д ирүүлнэ. Үүнд:

2.2.1. Судалгааны ажлын танилцуулга;

2.2.2. Судалгааны ажлыг гүйцэтгэнээр гарах үр дүн, практик ач холбогдлын паарх танилцуулга;

2.2.3. Грантаар хэрэгжүүлэх ажлын удирдамж, төлөвлөгөө, зардлын рийвчилсан тооцоо;

2.2.4. Грантын санхүүжилтээр зайлшгүй шаардлагатай ном, сэтгүүл, тоног хөөрөмж, багаж хэрэгсэл болон бусад материал худалдан авах бол тэдгээрийн талаарх лгэрэнгүй мэдээлэл;

2.2.5. Грантаар санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэх ажилтны ажил байдлын дорхойлолт, тухайн сэдэвтэй холбогдох бүтээлийн жагсаалт.

2.3. Грантыг олгоходоо Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн Захирал тушаал гаргана.

2.4. Грантаар санхүүжүүлэх ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэн, гүйцэтгэх ажилтны оронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлнэ.

2.5. Грантаар санхүүжүүлсэн ажлын үр дүнг Эрдмийн зөвлөл болон Захиралд лагнана.

## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ

**16 дугаар зүйл.** Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох рам

16.1. Энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх эрдэм шинжилгээ, ёшилт, зохион бүтээх ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу хянан магадлагаа йж шалгаруулна.

16.2. Энэ хуулийн 16.1-д зааснаар шалгарсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион тээх ажлыг санхүүжүүлэхэд олгох хөрөнгийн хэмжээг Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн инжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан ажлын захиалагч нь териин захиргааны төв болон гийн захиргааны байгууллага байх бөгөөд тэдгээр нь Иргэний хуулийн 343-358 дугаар 1лд заасны дагуу гүйцэтгэгчтэй төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулна.

16.4. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага үйл ажиллагааныхаа үндсэн тлэлийн дагуу суурь, хавсарга судалгааг гүйцэтгэх бол тэдгээрт грант олгох, эсхүл уг йгууллагад санхүүжилт олгох замаар асуудлыг зохицуулж болно.

16.5. Энэ хуулийн 15.1.3-д заасны дагуу 14.1.3-14.1.5-д заасан эх үүсвэрээс гүйцэтгэх дэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагч, гүйцэтгэгчийн хооронд йгуулсан гэрээний дагуу санхүүжүүлнэ.

16.6. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын барилга байгууламж, сорилт, јшилтын зориулалттай тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахтай холбогдсон өдлүүг улсын төсөвт тусгах, санхүүжүүлэх асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал кэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ

Хоёр. Хүрээлэнгийн үйл ажиллагааны зарчим, үндсэн чиг үүрэг

2.1. Хүрээлэн нь судалгаа, сургалт, сурталчилгаа, мэдээллийн байгууллагын ётлэг үнэт зүйл, зарчмыг үйл ажиллагаандаа удиртгал болгож, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Хууль зүйн бодлогын судалгааг суурь, харьцуулсан бие даан хийхийн зэрэгцээ сдаар захиалан гүйцэтгүүлж болно.

2.1.2. Хуулийн төсөл боловсруулах ажилд бодлогын болон хавсарга судалгаагаар тчлэхийн зэрэгцээ бусад мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Хууль зүйн бодлогын тон хавсарга судалгааг төрийн байгууллагын захиалгаар хийж болно. Захиалсан йгууллага судалгааны ажлын зардлыг хариуцна.

2.1.3. Эрх зүйн харьцуулсан судалгаа хийх, үндэсний хууль тогтоомжийн төлөв ёдал, хандлага хэрэгцээ, уялдаа, үр нөлөөг судалж санал, зөвлөмж, аргачлал товсруулна.

2.1.4. Төрийн захиргааны байгууллагуудад хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судлах үдлаар арга зүйн туслалцаа үзүүлнэ. Энэ чиг үүргийг зөвлөмж, аргачлал боловсруулах, үлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зэрэг арга хэлбэрээр хэрэгжүүлнэ. Холбогдох өдлүүг тухайн байгууллага хариуцна.